



**"ГЕРМЕС ЦЕНТР" ХУВЬЦААТ
КОМПАНИ**

**2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**

2016 ОН

КОМПАНИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

1. Үнэт цаас гаргагчийн нэр: "Гермес Центр" ХК
2. Нээлттэй хувьцаат компани
3. Хувьцааны төрөл: **Энгийн хувьцаа**
4. Хувьцааны анх нэрлэсэн үнэ: **100 төгрөг**
5. Өнөөдрийн байдлаарх зах зээлийн дундаж үнэ: **149 төгрөг**
6. Нийт хувьцааны тоо ширхэг: **78,543,001 ширхэг**
7. ТУЗ-ийн дарга: **Д.Оюунсүрэн**
8. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга: **Д.Эрдэнэсүрэн**
9. Гүйцэтгэх захирал: **Б.Оюунцэцэг**
10. Нягтлан бодогч: **З.Гончигсүрэн**
11. Холбоо барих утас: **976-11-301577**
12. Вэб сайт: **www.hermescenter.mn**

ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

"Гермес Центр" Хувьцаат компани нь 2016 онд Улаанбаатар хотод барилгын материалын худалдааны төвөө ажиллуулж ирлээ. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд нийт 16 ажилтан ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулсан.

1. Компанийн санхүүгийн тайлангийн үндсэн үзүүлэлтүүд:

- Нийт ажиллагсдын тоо: 16 хүн
- Нийт хөрөнгө: 8,402.8 сая төгрөг
- Эргэлтийн хөрөнгө: 1,541.2 сая төгрөг
- Үндсэн хөрөнгө: 6,861.6 сая төгрөг
- Эзэмшигчийн өмч: 7,854.3 сая төгрөг
- Хуримтлагдсан ашиг: 339.0 сая төгрөг буюу нийт хөрөнгийн дүнтэй харьцуулахад өр төлбөр 2.5%, эзэмшигчийн өмч 93.5%, хуримтлагдсан ашиг 4.0% байна.

2. Татварын өр төлбөрийн тухай:

Нийт компанийн хэмжээнд 2016 онд ААН-ийн ОАТатварт 78,3 сая төгрөг, ажиллагсдын цалингаас суутгасан ХХОАТатварт 23,1 сая төгрөг, НӨАТатварт 136,8 сая төгрөг, ҮХЭХАТатварт 56,5 сая төгрөг, хувь хүний суутгалын татварт 3,2 сая төгрөг нийтдээ улсад 367,3 сая төгрөг төлсөн бөгөөд татварын ямарваа нэгэн өр төлбөргүй ажилласан болно.

3. Орлого үр дүнгийн тухай:

Манай компани 2016 онд нийтдээ 1 367.7 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан. Жилийн эцсийн дүнгээр түрээсийн орлогын нийт дүн төсөвлөсөн 1 333.8 сая төгрөгтэй харьцуулахад 103%-ийн биелэлттэй байна.

4. Зардлын тухай:

Компанийн хэмжээгээр 2016 онд 706.9 сая төгрөгийн зардал гаргасан болно. Зардлын төлөвлөгөө 823.7 сая төгрөг байсантай харьцуулахад төлөвлөгөөний биелэлт 86%-ийн биелэлттэй гарсан. Компанийн хэмжээгээр зардлыг төсөвлөснөөс 116.7 сая төгрөгөөр хэмнэж ажилласан.

5. Ашгийн тухай:


Компанийн хэмжээгээр 2016 оны эцэст 672.5 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан. Ашгийн төлөвлөгөө 525.5 сая төгрөг байсантай харьцуулахад 128%-иар буюу 147.0 сая төгрөгөөр давуулан биелүүлж ажилласан.

Аудитын байгууллагаар баталгаажсан 2016 оны санхүүгийн тайлан балансаар тус компани нь нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн төлөвлөгөөг дараах байдлаар биелүүлжээ. Үүнд:

- 2016 оны нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ төлөвлөгөө 6 төгрөг 69 мөнгө
- 2016 оны санхүүгийн тайлангаар нэгж хувьцаанд оногдох ногдол ашигийн хэмжээ 8 төгрөг 51 мөнгө болж гарсан


ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГ

/сая төгрөг/




ЦЭВЭР АШИГ, АЛДАГДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

/сая төгрөг/




ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨР

/сая төгрөг/




ОРЛОГЫН БҮТЭЦ-2016 ОН

/Нийт орлого 1,489.8 сая төгрөг/




БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

/сая төгрөг/




НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШИГ

/төгрөг/




ЦАЛИН УРАМШУУЛАЛ НӨӨЦИЙН САН 2016 ОН

/сая төгрөг/




НИЙТ ХӨРӨНГӨД ӨР ТӨЛБӨРИЙН ЭЗЛЭХ ХУВЬ 2016 ОН




ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ 2016 ОН

/Нийт хөрөнгө-8,535.2 сая төгрөг, Нийт элэгдэл-1,673.6 сая төгрөг, цэвэр хөрөнгө 6,861.6 сая төгрөг//




ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ 2016 ОН

/Нийт 1,541.2 сая төгрөг/




НИЙТ ХӨРӨНГӨНД ЭЗДИЙН ӨМЧ ЭЗЛЭХ ХУВЬ 2016 ОН

/сая төгрөг/



БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР 2016 он

/Нийт - 209.4 сая төгрөг/



ТҮРЭЭСИЙН ТАЛБАЙН ҮНЭ ТАРИФ

/₮/

	2013	2014	2015	2016	2017
Лангуу	125 000	150 000	150 000	150 000	150 000
2-р давхар /павильон/	17 000	20 000	20 000	18 000	17 000
1-р давхар /павильон/	21 000	25 000	25 000	21 000	20 000

Жич: Оны эхний 1,2,3-р саруудад түрээсийн төлбөрт 10%-ийн хөнгөлөлт үзүүлдэг.